

Chronik

ТҮҮХЭН ТӨВЧӨӨН

# МОНГОЛ УЛС ТӨВ АЙМАГ



Chronik  
MONGOL

NERKO  
MONGOLIA

ТӨВ АЙМАГ  
ОУ ДАРГААНИЙ КАРТАЙ

**МОНГОЛ УЛС**  
**ТӨВ АЙМАГ**  
**ОН ДАРААЛЫН БИЧИГ**

**Chronik**  
MEDIA

**NEPKO**  
PUBLICATIONS



# МОНГОЛ УЛС ТӨВ АЙМАГ он дарааллын бичиг

Амхны хэвлэлт

**Зохиогч:** Чунтын Болдбаатар

**Зөвлөх:** Баабар

**Ерөнхий редактор:** Бат-Амгалангийн Болдбаатар  
Бямбажавын Цэнддоо

**Техник редактор:** Вандангийн Уянга

**Зураг чимэглэл:** Нямжавын Бямбацогт

**Дизайн:** Нямжавын Бямбацогт

**Хроник:** Шагдарсүрэнгийн Цэрэндоо

**Гэрэл зураг:** Темертогоогийн Алтантөгс

Дашдэлэгийн Батбаяр

Дашнямын Батболд

Доржоохүүгийн Батболд

Бавуудоржийн Баттулга

Жамсрангийн Баяржаргал

Пүрэвдоржийн Болорчимэг

Санжаагийн Борхүүхэн

Гамма агентлаг

Чулуунбаатарын Ганбат

Жамсранжавын Гэрэлбадрах

Шаравын Гэрэлсайхан

Нацагийн Дашлэгцэгмаа

Зоригтын Лонжид

Нямдоржийн Мянмар

Нямхүүгийн Одхүү

Шаравын Отгонжаргал

Тэгнүүлын Ерөнхий Газрын архив

Тоншуул сэтгүүл

Төв аймгийн музей

Бямбажавын Түвшинтөгс

Жамсрангийн Урангуа

Copyright © 2012 wissenmedia GmbH, Gütersloh/München for the Chronicle System

Published in its Originals Edition 1995 with the Title

'Title of the licensed chronicle'

by wissenmedia GmbH, Gütersloh/München

Copyright © 1995 wissenmedia GmbH, Gütersloh/München

Copyright © 2013 НЭПКО Паблицинг (монгол хэвлэл)

НЭПКО хэвлэлийн газарт эхийг бэлтгэж, "Мөнхийн Үсэг" ХХК-д хэвлэв.

Улаанбаатар 2013 он

Толомт хотхон, С байр 11 тоот, Сөүлийн гудамж, Ш/х 2327, Улаанбаатар 211213, Монгол Улс

Утас/факс: 976-11-326329

И-мэйл: info@nepko.mn

Вэб сайт: www.nepko.mn

ISBN 978-99962-66-49-0

# Мэндчилгээ



Ц.Мэндсайхан



Д.Баярбат

Түшээт хан аймгийн халуун голомтыг бадраан хөгжүүлэх дэлгэр хувь зохиолтой Төв аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн баярыг тохиолдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчид, Ажлын алба, аймгийн Засаг дарга, Засаг даргын Зөвлөл, Тамгын газрын өмнөөс чин сэтгэлийн халуун баяр хүргэж, өнө урт насалж удаан жаргахын өлзийтэй ерөөлийг өргөн мэндчилье.

Азийн зүрхэн болсон Монгол нутагт улс түрэн, төрт ёс үүсэж хөгжсөн буурал түүхийн туршид бидний төрлөх нутаг-Төв аймаг зохих байраа эзэлсээр иржээ.

Манай аймаг, арванзургаадугаар зууны үед байгуулагдсан Түшээт хан аймгийн түүхийг улбаалан 1923 оноос өнөөгийн хөгжлийн түүхээ эхлүүдснээс хойш 90 жилийн өндөрлөгт хүрлээ.

Бүтээлч, хөдөлмөрч иргэдийн маань шаргуу хөдөлмөр, Нутгийн удирдлагын байгууллагын оновчтой удирдлагын үрээр өнөөдөр манай аймаг 27 сумтай, 97 багтай, 87,4 мянган хүн амтай, 3.2 сая малтай, 200 мянга гаруй тариангийн эргэлтийн талбайтай, жилд 80 гаруй мянган га-д тариалалт хийдэг, аж үйлдвэр, барилга, уурхай, сургууль, эмнэлэг, соёлын байгууллага зэрэг нийгэм, эдийн засгийн бүхний салбар цэцэглэн хөгжсөн, улс, орныхоо хөгжилд дорвитой үүрэг гүйцэтгэдэг томоохон аймаг болон хөгжиж байна.

Манай аймгийн хөдөлмөрч хичээнгүй АРД ТҮМЭН гэгээн түүхийнхээ замд эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах, нийгмийн хөгжлийн цаг үе бүхэнд дэвшингдсэн улс төр, эдийн засаг, аж ахуй, соёлын зорилтуудыг хэрэгжүүлж, бүтээн байгуулах үйлсийг түүчээлж, нутаг орноо цэцэглүүлэн хөгжүүлэхэд чармайн зүтгэж ирлээ.

Энэ ч учраас Төв аймгийн ногоохон туг дээр төрийн хүндэтгэл Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон гялалзаж, Төвчүүдийн эгнээнээс төрийн нэрт зүтгэлтэн Д.Бодоо, Д.Чагдаржав, тэргүүн сайд, да лам Г.Цэрэнчимэд, Манзушир хутагт С.Цэрэндорж, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу, шашин соёлын зүтгэлтэн Халхын хоёрдугаар богд Лувсандамбийдонмэ, гүн ухаантан Агваанхайдав, хамба номун хан Пунцаг, тэргүүн хамба соёлын гавьяат зүтгэлтэн Д.Чойжамц, Улсын баатар Д.Самдан, Б.Цог тэргүүлэн 60 шахам хөдөлмөрийн баатар, 200 гаруй гавьяат цолтон төрсөн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар аймгийнхаа иргэдийн амьжиргааны чанарыг дээшлүүлэх, шийдвэр гаргахдаа иргэдийнхээ оролцоог хангаж, улмаар хөгжлийн хурдацыг түргэтгэх олон чухал зорилт, арга хэмжээг үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жил жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд дэвшүүлсэн зорилтуудаа амжилттай биелүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Манай аймгийн нутагт өнөө үеийн их бүтээн байгуулалт болох «Олон улсын нисэх онгоцны буудал», «Их Майдар» цогцолбор, «Шинэ төмөр зам», «1000 айлын орон сууц» зэрэг төслүүд эхлэн хэрэгжиж, цаашид хийхээр төлөвлөгдөж байгаа нь аймгийн хөгжлийг түргэтгэх, ард иргэдийн маань амьдарлыг дэвшүүлэхэд чухал түлхэц болно.

Төв сайхан нутгийнхаа 90 жилийн ойг тохиолдуулан нийт иргэд Та бүхэндээ аймгийнхаа эрчимтэй хөгжлийг хангахад үнэтэй хувь нэмэр оруулахыг хүсч, аз жаргал, эрүүл энх, сайн сайхныг ерөөе.

Аймгийн

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

  
Ц.МЭНДСАЙХАН

Засаг дарга

  
Д.БАЯРБАТ



Аяыг: Ц.Нацагдорж  
Шүлгийг: Ш.Сүрэнжав

### ТӨВ АЙМГИЙН СҮЛД ДУУ

Хан Богдын өвөр дахь хашийн цагаан өргөө  
Халиун буга урамдсан Зуунмодны шаргиа  
Найргийн тэнгэр Нацагдорж онгодоо хайрласан өлгий  
Наадмын түрүү бөхчүүд одтой гялалзсан дэвжээ

Нэр нь хүртэл төв  
Дур нь хүртэл төв  
Төв сайхан нутаг  
Төв аймаг манайхаа

Атрын хөрсийг чимсэн алтан тарианы шаргиа  
Отрын хөндийд тургилсан адуун сүргийн бараа  
Айргийн сөнгийн дэргэдээс дуурсах яруу аялгуу  
Ангирт нуурын мандлыг сувдаар бүрсэн орон


Нэр нь хүртэл төв  
Дур нь хүртэл төв  
Төв сайхан нутаг  
Төв аймаг манайхаа

Уулын энгэрт шивээлсэн уран Манзуширын хийдээ  
Туулын усанд тольдсон улсын Нийслэлийн нутаг аа  
Уран байгалийн бүтээл Ээж хадны увидас аа  
Усан байгалийн гялалзсан Горхийн цэнхэр уулсаа

Нэр нь хүртэл төв  
Дур нь хүртэл төв  
Төв сайхан нутаг  
Төв аймаг манайхаа

Хурдны морьдын давхианд цугтаа эргэсэн салхи аа  
Хуртай зуны сардаа чийг хадсан газар аа  
Алтан соёмбот баатруудын өлгий болсон нутаг аа  
Ажилсаг түмнийхээ сэтгэлд од шиг гялалзсан орон

Нэр нь хүртэл төв  
Дур нь хүртэл төв  
Төв сайхан нутаг  
Төв аймаг манайхаа





**ХАЛХЫН  
ХААНТ УЛС**




**ТҮШЭЭТ ХАН  
АЙМАГ**



**БОГД ХАН  
УУЛЫН  
АЙМАГ**



**ТӨВ  
АЙМАГ**



## ӨМНӨХ ҮГ


Төв аймгийн түүхэн замнал, засаг захиргааны түүхийн он дарааллын бичгийг уншигч танд барьж байна. Аймаг орон нутгийн түүх бол улс үндэстнийхээ тулгын чулууны нэг, Монгол Улсын түүхийн салшгүй нэгэн бүрдэл билээ. Ийм учраас Халхын хаант улс байгуулагдаж эхэлсэн үеэс эхлүүлэн өнөөг хүртэлх нийт монголчуудын түүхийг суурь үндэс болгон авлаа. Төв нутгийн иргэд хийгээд орон нутгийн түүх шастир сонирхон судлагч хэн боловч эх орныхоо түүхийг, эл аймаг газрын түүхтэй хослуулан харах, үзэх боломжтой байхаар бодож хийлээ.

Орон нутгийн түүхийн товчоон, он дарааллын бичигт өрнө дахины хронологийн стандарт түвшинд нийцэн анх удаа гарч байгаа нь энэ. Он дарааллын бичиг бүтээх аргачлал, эрхийг Герман

улсын Хроника хэвлэлийн газраас авсан болно. Үүний өмнө дээрх газрын хэвлэл нийтлэх эрхийн хүрээнд НЭПКО хэвлэлийн газраас гаргасан *Монгол Улс 100 жил (1911-2011)* номыг улсынхаа түүхийн сурвалж, суурь болгон ашиглалаа. Уг бүтээл 1911 оноос хойших үеийг хамарч байсныг 500-аад жилээр урагшлуулан Халхын хаант улс байгуулагдсан үеэс эхлүүлэн өгүүлсэн болно.

Орон нутгийн түүх бичлэг, он дарааллын хроник бүтээх ажлыг шинэчлэх, орчин цагийн туурвил зүйн жишигт хүргэх санаачлагыг халуун дэмжиж хүлээн авсан Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газарт талархснаа илэрхийлж байна.

*НЭПКО хэвлэлийн газар*



**ОРОСТОЯ ХАРИДЦАХ ЗАМ**



**ТОМЬЁЛСОН ТЭМТЭГ**

●	<b>Бээжин</b>	улсын нийслэл хот
○	Эрдэнэ зуу 1586	бусад хот суурин, түүний байгуулагдсан он
— — — — —		Ар Өвөр, Баруун монгол-ин хил
— — — — —		Халхын Түшээт хан, Засагт хан, Цэцэн хан
.....		Цахар түмэдийн зааг
.....		Аймаг хошуудын нутгийн зааг
—————		Ачаа жингийн их зам
●		Зүүн гарын хааны өргөө (1634—1664 он)
~~~~~		Хятадын цөгөөн хэрэм
▭		год мөрөн, нуурууд



# МОНГОЛ ОРОН

# XVII

## ЗУУН

1617. Халхын Цогт хун тайжийн Цагаан байшин баригдаж дуусчээ.

1624. Хорчин, Дөрвөд, Жалайд, Гөрлөс аймаг Манжид дагаар оржээ.

1625. Лигдэн хаан Манжид дагаар орсон Хорчин, Дөрвөд, Жалайд, Гөрлөс аймгуудыг цэрэрүүлэхээр цэрэг илгээжээ.

1627. Өвөр Халхын 5 отог, Харчин, Найман, Аохан аймгууд Манжид дагаар оров.

1628. Сибирт Красноярскийн шинэз байгуулагдав.

1628. Монгол алтан ганжуурыг анх эмхлэн гаргажээ.

1631. Лигдэн хаан Хянганы нурууг давж Хорчин, Түмэдийг бут похжээ. Манж нар Харчин, Асуд, Найман, Жаруд зэрэг аймгуудтай хүч хавсран Цахарын цэргттэй байллав.

1632. Манжийн Дээд Эрдэмт хаан Цахарыг довтолж, Лигдэн хаан Хөх нуурын зүг зуттав.

1634. Лигдэн хутагт хаан Манжаас зутган Хөх нуурыг зорин явах замдаа Шар тал гэдэг газар өвчнөөр нас барав. Халхын Цогт хун тайж Хөх нуурт нүүж очиж, Хөх нуурын Амдо газрыг байлдан эзлэв. Жалханз хутагтын анхны дүрийг тодруулав.

1635. Анхдугаар богд Жибзундамба Өндөр гэгээн Луvsандамбийжалцан төржээ. Халхын Цогт тайж Түвдийн Үй, Зан мужуудыг байлдан эзлэхээр цэргээ илгээв.

1636. Өвөр Монголын 16 аймгийн чуулган Мүтдэнд болж Өвөр Монгол Манжид дагаар оров. Монголын Засгийг эрхлэгч яам байгуулагдав. Манжийн хаан Абахай өөрийгөө Монголын хаан хэмээн өргөмжлөв. Манжийн хааны оронд Халхын Сэцэн хан Шолой тэргүүтэй ноёд дагалдсагд 132 хүнийг хамт хүрэлцэн очив. Халхын ноёд Манжийн хааны санд 9 цагааны алба барьж эхлэв.

1637. Халхын Цогт тайж, хошуудын Төрбайх гүүш хан нар Хөх нуурын эхэнд тулгаран байджээ. Засагт хан Субадай Манжийн түрэмгийдлийг эсэргүүцэн Хөх хотыг цэргийн хүчээр уулзалан довтолжээ.

## ХАЛХЫН ТҮШЭЭТ ХАН АЙМАГ

Гэрсэнз хунтайж өөрийн өмч эзэмшил 12 отгийг долоон хөвүүндээ хуваан өгч, Халх 7 хошуу бий болсон үеэс Халхын гурван хаант улсын үндэс тавигджээ. Халхын 7 хошуу зүүн, баруун хоёр гарт хуваагдаж байв. Халхын зүүн гарт Гэрсэнзийн гутгаар хөвүүн Онохуй, дөтгөөр хөвүүн Амин-Дурал, тавдугаар хөвүүн Дарь нарын өмчийн хошуунаас бүрдэж байсан бөгөөд Дарь тайж үргүй өнгөрсөн тул зүүн гарыг Онохуй үйзэн, Амин Дурал нар хуваан захирах болсон ажээ. Халхын зүүн гарын нутаг Хантайн уулнаас Халхын голоор савлаж, Хэрлэн голоор зааглагдаж байв. Гэрсэнз жалайр хунтайжийн ач Абтай сайн хан XVI зууны үед өөрийгөө хан өргөмжилснөөр эзэмшил нутгийг нь хожим Түшээт хан аймаг хэмээжээ. Үүнд Гэрсэнзийн хөвүүн Онохуй үйзэн, ахмад хөвүүн Абтай, түүний хөвүүд Субгаадай, Эрээхий мэргэн ноёны албат харьяат нар Түшээт хан аймгийн арын 14 хошуу, харин дэд хөвүүн Абахуй, түүний ахмад хөвүүн Ангаахай мэргэн, дэд хүү Рахуул далай ноёны албат харьяат нар нь Түшээт хан аймгийн өөрийн 6 хошууны өвөг дээдэс нь болжээ. Өнөөгийн Төв аймгийн нутаг нь Түшээт хан аймгийн Дархан чин ван, Зоригт ван, Баатар ван, Сэцэн ван, Дайчин бэйс, Сүжигт гүн, Илдэн гүн, Жонон гүний хошуу, мөн Сэцэн хан аймгийн Боржигон Сэцэн вангийн хошууны нутаг дэвсгэрээс тогтож байв.

## ХАЛХЫН АБТАЙ САЙН ХААН



Абтай сайн хаан. Эрдэнэзуу хийдийн хангын зураг

Халхын Абтай сайн хаан бол Гэрсэнз жалайр хунтайжийн 7 хөвүүний дундах Онохуй үйзэн ноёны ахмад хөвүүн бөгөөд модон барс жил (1554) төржээ. Эх нь Халхын хилует отгийн эзэн Бөхийн охин Эцэнхэн зоригт хатан аж. Тэрбээр эрэлхэг зоригтой баатар эр байснаас галзуу ноён хэмээн алдаршиж Түшээт хаан цолтойгоор Халх Монголыг бүхэлд нь захирч байв. 1577 онд Агбаржин жононгийн өш хонзонг авахаар шалтаглан Ховхор хэрээ гэх газар Ойрадыг дарж захиргаандаа оруулж улмаар Халх Монгол Улс ихэд хүчирхэгжсэн ажээ. Түүний ахмад хөвүүн Субгаадай хунтайж Ойрадыг захирч, дэд хөвүүн Эрээхий нь угсаа залгамжилжээ. Абтай сайн хаан 1586-87 оны үед өмнөд Монголын Түмэдэд хүрэлцэн ирсэн Түвдийн III Далай лам Содномжамц-тай уулзан шашинд нь орж, Халх Монголд шарын шашныг дэлгэрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлсэн ба Халхад шарын шашны анхны хийд Эрдэнэ зуу-г 1588 онд байгуулжээ.

## ЭРДЭНЭЗУУ ХИЙД

Хийд байгуулах санааг 1580 онд Абтай сайн хаан гаргаж, III Далай лам Содномжамцын зөвлөсний дагуу Хархорум хотын туурин дээр байгуулсан. Эрдэнэзуу хийдийг шашны сүм хийд, барилга барихад дагадаг тодорхой

# XVII

## ЗУУН



Монголын анхны хийд-Эрдэнэзуу

аргыг баримтлан олон арван жилийн турш барьсан. 1586-1674 онд Гурван зуу сүмийн чуулбар, Ригсүм Гомбо сүмүүдийг, 1701-05 онд Очирдарь бурхны сүм, Авид бурхны сүм, Их суварганы чуулбаруудыг босгосон. 1796 онд хийд анх удаа их засварт орж энэ үеэр хуучин Тахай балгасны хэрмэн нурангийг суурь болгон 50 ширхэг суварга босгосон. Үүний дараа 1802-13 онд хаад, тайж, бэйл, лам, ардуудын хандиваар дахин 56 суварга нэмж хэрмэн ханыг барьж дуусгасан. Хийдийн тойрон хүрээлж буй 108 суварга бүхий хэрмэн хашаа нь хааш хаашаа 420 метр. Ийнхүү 1792 он гэхэд 62 сүм, 500 гаруй барилга байшинтай болсноос өнөөдөр 18 сүм нь үлдсэн. Хийдийн дотор байрлах Лаврин сүм нь Монголд байгаа түвд маягийн цорын ганц сүмд тооцогддог. 2004 онд хийдийг ЮНЕСКО-ийн Дэлхийн соёлын үнэт өвд бүртгэсэн.

## ТУСГААР ТОГТНОЛЫГ ХАМГААЛАГЧ



Дуутын хийдн бичлэг

Халхын ноёд язгууртнуудын дунд шарын бус улааны шашныг талархагч цөөнгүй байв. Тэднээс хамгийн нэр нөлөөтэй нэгэн бол Онохуй үйзэнгийн ач, Бахарай хошуучийн хөвүүн Цогт хунтайж (1581-1637) юм. Тэрээр төвлөрсөн засаглалыг дэмжиж байсан тул Монголын сүүлчийн хаан Лигдэнтэй улс төрийн холбоо тогтоожээ. Лигдэн хааныг дэмжиж, Манжийн үзэл суртлын туг болж байсан шар мангайтны эсрэг улаан

1638. Манжийн хаан Халхын ноёдыг жил бүр 9 цагааны алба барихыг тулгав. Монголын засгийг эрхлэгч яамыг Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам болгон өргөтгөв.

1639. Халхын ноёд Ширээ цагаан нуур хэмээх газар цуглаарч, Түшээт хан Гомбодоржийн хөвүүн Занабазарыг Халх Монголын шарын шашны тэргүүнээр өргөмжлөв. Занабазар нь Монголын түүхэнд анхдугаар Богд Жибзундамба буюу Өндөр гэгээн хэмээн алдарджээ. Хошуудын Төрбайх ноён Камыг довтлов.

1640. Тарвагатайн Улаан бураа хэмээх газар Халх, Ойрадын чуулган болж «Дочин дөрвөн хоёрын их цааз» баталжээ. Анхдугаар Богд Жибзундамбад Бат оршил өргөх даншиг наадм болжээ. Үүнээс хойш долоон хошуу даншиг наадм уламжлагддаг.

1644. Ойрадын Галдан бошгот хаан төрөв.

1646. Сөндрийн Тэнгис ноён Манжийн эсрэг босч харьяат иргэдээ авч Халхад нүүж ирөв.

1648. Рабжамба Зая бандид Намхайжамц тод бичиг зохиожээ.

1652. Сэцэн хан Шолой нас баржээ.

1653. Түшээт хан Гомбодоржийн дүү Бунтар албат харьяатаа аяч Манжийн хаанд дагаар оров.

1654. Монголын буриад нарын нэг хэсэг нь Орос улсад дагаар оров.

1655. Манжийн хааны шахалтаар Түшээт хан Чахундорж тэргүүтэй Халхын ноёд хөнгүүд, дүү нараа Манжийн хааны ордонд илгээн, Халхын Түшээт хан Гомбодорж нас барав. Гүүш Лувсанданзангийн «Алтан товч» зохиогдов.

1657. Халхын Засагт хан Манжийн хаанд аяч илгээж бичиг барив.

1661. Эрхүү хотын анхны суурь болох шивээ байгуулагдла. Засагт хан Норов нас барав.

1662. Саган Сэцэний «Эрдэнийн товч» зохиогдов. Ойрадын Зая бандид Намхайжамц нас барав.

1665. Баатар хун тайжийн хүү Сэнгэ Цоросын хан ширээнд суув.

1666. Буриадын Үлэд Оросын шивээ байгуулагдла.

# XVII

## ЗУУН

1670. Цэнгүн Засагт ханы ширээнд суув.

1675. Бүрнэ, Лувсан нар Манжийн ноёрхолыг эсэргүүцсэн бослого гаргав.

1676. Галдан бошгот бүх Ойралыг эрхэндээ оруулж Зүүнгарын хаант улсыг байгуулав.

1678. Галдан бошгот Хөх нуурыг эрхэндээ оруулав. Галдан бошгот Дорнод Түркестаныг довтлов.

1682. Далай ламын анхны элч Халхад хүрэлцэн ирэв.

1685. Галдан бошгот хаан Ховдын голд цэргийн тариалангийн суурин байгуулсан нь Ховд хотын үүсэл суурь болжээ. Их эрдэмтэн Ш.Мингат төржээ.

1686. Манжийн хааны санаачилгаар Заг, Байдраг голын эх Хүрэн бэлчир гэдэг газар Халхын ноёдын чуулган хуралдав. Өндөр гэгээн Занабазар соёмбо үсэг зохиожээ.

1687. Халхын Түшээт хан Чахундорж Галдан бошгот нар байлдав.

1688. Халх-Ойралын дайн өрнөв.

1689. Манж-Оросын Нэрчүүгийн гэрээ байгуулагдлаа.

1690. Улаанбутан хэмээх газар Галдангийн цэрэг Манжийн цэрэгтэй тулалдан ялагджээ. Галдан бошгот Завхан, Хунгүй голоор дайран Ховлод ирж суурив.

1691. Манж Чин улс Халх Монголыг захиргаандаа оруулсныг Халх, Өвөр Монголын ноёдыг оролцуулан Долоннуурын чуулганаар албан ёсоор баталжээ.

1692. Халхын Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан аймгийг манж нар 3 зам болгон хуваав.

1696. Галдан бошготын цэрэг Манжийн цэрэгтэй Тэрэлжийн Зуун модны газар шийдвэрлэх тулалдаан хийж цохигдов. Хөх нуурын ноёд Цагаан толгой гэдэг газар чуулган чуулж, Манжийн эсрэг тэмцэхээр тогтов.

1697. Цэвэрравдан хаан өөрийгөө Зүүнгар улсын хаан өргөмжлөв. Галданбошгот хаан нас барав.

1698. Оросууд Удийн шивээт хот болгож, Дээд Үд гэж нэрлэв.

1699. Түшээт хан Чахундорж нас барав.

урсгалыг сөргүүдэн тавьж, түүнийг хөхиүлэн дэмжиж байсан Цогт тайжийн байр суурийг Халхын ноёд таашаахгүй байсан юм. 1601-1618 онд Халхад шашин дэлгэрүүлэхээр хүчин зүтгэж бурхны шашны сүм барьснаас Цогтын цагаан байшингийн туурь нь үлдэж хоцорчээ. 1634 онд Халхын ноёдтой муудалцаж харьяатаа авч Хөх нуур, Түвдийн Амдо мужийг эзлэн суусан бөгөөд 1637 онд шарын урсгалыг хамгаалахаар ирсэн Ойрад-Монголын нэгдсэн цэргийн хүчинд ялагдан алагджээ. Цогт тайж Энэтхэг, Түвдийн утга зохиолоос монгол хэлнээ орчуулгуудыг, өөрөө шүдлэг зохиол бичдэг байсан нь Дуутын хаданд мөнхрөн үлджээ.

## ТҮШЭЭТ ХАН ГОМБОДОРЖИЙН ҮЙЛ ХЭРЭГ



Түшээт хан Гомбодоржийн бусан

Халхын Түшээт хан Гомбодорж бол Абтай сайн хааны ач, Эрээхэй мэргэний хөвүүн бөгөөд эцгийн орыг залгаж, Халх Монголыг хүчирхэгжүүлэх бодлогыг явуулжээ. Тэрбээр Халх Монголыг шашны тугийн дор нэгтгэхийг зорьж, Өмнөд Монголыг эзлэн хүчирхэгжсэн манж нартай эвээр харилцах бодлого барьж 1638 онд бэлэг бүхий элч зарж байв. Түшээт хан Гомбодорж 1640 онд Монгол, Ойрадын Улаан бураагийн чуулганд оролцож, Монгол-Ойрадын цаазыг батлалцсан ажээ. 1646 онд Манжийн эсрэг босон тэмцэж Халхын Сэцэн хааны нутагт нүүн ирсэн Өмнөд Монголын сөнөд аймгийн Тэнгис ванг өмгөөлөн хоёр түмэн цэргээ илгээн Манжтай байлдаж явжээ. 1651 онд Монгол-Манжийн харилцаа хурцадсан хүч тэнцвэргүй нөхцөл байдлын улмаас Түшээт хаан Манжийн хаантай найрамдахаар есөн цагааны ёсны бэлэг явуулсан байдаг. Гомбодорж хааны үед Халх Монгол Улс Манж Чин Улсын хараат болоогүй тусгаар байдлаа хадгалан оршиж байв. Түшээт хан Гомбодорж нь Халх Монгол Улсын хамгийн нөлөөтэй эзэн байсан билээ.

## ХАЛХЫН ШАРЫН ШАШНЫ ТЭРГҮҮН ЗАНАБАЗАР

Түшээт хан Гомбодорж Халх Монголыг шашны тугийн дор нэгтгэхийг зорьж, Шолой Сэцэн хаантай тохиролцож улмаар хөвүүн Занабазарыг 1639 онд Халхын шарын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагтаар өргөмжилжээ. Ийнхүү Гэгээн цол авч Халхын шарын шашны тэргүүнд өргөгдсөнөөр анхдугаар Богд Жибзундамба буюу Өндөр Гэгээн хэмээн алдаршсан. Бата наснаасаа номын мөр хөөн, Лхаст мориж Далай ламд шавь орж суралцсан ба V Далай лам түүнд хутагтын өргөмжлөл, шар торгон шүхэр, тамга шагнажээ. Нутагтаа эргэж ирээд шашин номын ёсыг дэлгэрүүлэх үйлсэд хичээн зүтгэж, Халх даяар сүм хийд олныг байгуулжээ. Үүнд 1648 онд Баруун Хүрээ буюу Шанхын хүрээг үүсгэн мөргөлийн төв болгосон ба 1655 онд Их хүрээ, Хангай ханы Төвхөнд бүтээлийн сүм, 1710 онд Хэрлэнгийн Зүүн хүрээг цогцлоосон. Дорно дахины 10 ухаанд мэргэшсэн ялангуяа урлахуйн ухааны эрдэмд гарцсан уран дархны хувиар цутгамал баримал, зурмал хөөмөл бүтээл олныг

# XVIII

## ЗУУН



Занабазарын хэрэг

байсан бөгөөд соёмбо бичиг-ийг зохион, түүгээрээ Итгэл зэрэг судар барлуулсан. Соёмбо бичгийн бярга соёмбо нь Монгол Улсын өнөөгийн төрийн далбаан дээр буй. Өндөр Гэгээн Халхын оюун санааны удирдагчийн хувьд улс төрийн амьдралд идэвхтэй оролцон төр түмэндээ эв эеийг тунхаглаж байв.

## ШАР БҮСИЙН ХОТ

Чингис хааны гал голомтыг төрийн гал голомт хэмээн онголон үе улиран хадгалан тахиж ирсэн бөгөөд Абтай сайн хааныг 1589 онд тэнгэрт халихад шарын шашныг Халхад дэлгэрүүлэх үйлсэд байгуулсан гавьяаг нэхэж түүний өргөөг Эрдэнэ зуугийн хэрмэн дотор мөнхжүүлсэн гэдэг. 1639 онд түүний ач хөвүүн Түшээт хан Гомбодорж төрийн гал голомтыг шилжүүлэн Их Монгол уулын өвөр Ширээ цагаан нуурын хөвөөнд авчирч, өвөг дээдсийнхээ гал голомтны зүүн талд тусгай өргөөнд өөрийн хөвүүн Занабазарыг Халхын шарын шашны тэргүүнд өргөмжилжээ. Энэ үеэс өвөг дээдсийн гал голомтыг Баруун өргөө, шарын шашны гал голомтыг Шар бүсийн хот гэх болсон аж. Ингэж Монгол төрийн гал голомт, шашны гал голомттой зэрэгцэн орших болсон бөгөөд Шар бүсийн хот нь хөгжин хөгжсөөр *Хутагтын өргөө*, *Их Хүрээ*, *Номын их хүрээ* гэх нэртэйгээр 1855 он хүртэл 28 удаа нутаг сэлтэн нүүдэллэсээр Хан уулын ар, Хатан Туулын сав, Алтан тэвшийн хөндийд бүрмөсөн суурьшсан нь өдгөө Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын уг үндэс болжээ.

## ХҮРЭНБЭЛЧИРИЙН ЧУУЛГАН



Заг Байрагийн Хүрэн бэлчир

үйлдсэн. Уран бүтээлчийн хувьд өөрийн болон эх Ханджамц хатны хөргийг зурж, Ногоон дарь эх, Цагаан дарь эх, Язгуурын таван бурхан зэрэг уран баримал бүтээсэн нь буддын шашны бурхан бүтээх хэвшмэл тиг, загварт баригдалгүй хүний биений гоо сайхныг нээн харуулснаараа өвөрмөц байдаг. Эдгээр бүтээлээрээ Занабазар Монголын дүрслэх урлаг, уран барималд шинэ чиглэл нээсэн хэмээн үнэлэгддэг. Тэрээр буддын философийн тайлбар, шашны зан үйлийн талаар нэгэн боть зохиол түвд хэлээр айлтгасан бөгөөд *Адистидийн дээдийг хайрлагч* (түвд. *Жанлаб цогзол*) зохиол нь түвд утга зохиолд ихэд алдаршсан. Занабазар соён гэгээрүүлэгч

1701. Өндөр гэгээн Занабазар Эрдэнэзууг сэргээн засварлав.

1704. Зохиолч Сүмбэ хамбо Ишбалжир төрөв.

1705. Ойрадын Лхавзан хаан Түвдийг эзэлж Дэсрид Санжаажамцыг хороов.

1706. Өндөр гэгээн Эрдэнэ толгойд Заамы хийдийг байгуулав.

1709. Халх журам хууль зохиогдов.

1711. Хэрлэний зүүн хүрээ Шаддүвчойнхорлин байгуулагдав.

1716. Зая бандид Лувсанпэрэнлэй 74 насандаа жанч халав.

1717. Манж монгол үгний толь бичиг 21 дэвтэр хэвлэгдэв. Ховд голд манжийн цэргийн тарианы суурин байгуулагдав.

1719. Монголд манжийн цэргийн өргөө байгуулагдав.

1720. Лигдэн хааны үед бэлтгэсэн Монгол Ганжуурыг хэвлэв.

1722. Эрдэмтэн Ш.Мянгатын «Тооны ухааны нарийн хуримтлал» 53 боть ном зохиов.

1723. Өндөр гэгээн Занабазар жанч халав. Жибзундамба хутагтын шавь нарын хэргийг эрхлэх Эрдэнэ Шанзудбын яам байгуулав. Одоогийн Завхан аймгийн Идэр сумын нутагт Ялгуусан гэгээний хүрээ байгуулагдав.

1724. II Жибзундамба хутагт Лувсандамбийдонми төрөв.

1725. Халхад Сайн ноёны аймаг байгуулагдав. Гүн Гомбожав Гангын урсгал хэмээх түүхийг зохиов.

1727. Оросын гүн Сава Рагузинский Хиагтын ойр Буурын голд Манжтай хилийн хэлэлцээр байгуулав. Хиагт хот байгуулагдав. Зүүнгар улсын хаан Цэвээнрандан нас барж Галданцэрэн хаан ширээнд суув. Амарбаясгалант хийдийн суурийг тавив.

1729. Ховдын тарианы сууринг цэргийн бэхлэлт болгов.

1730. Одоогийн Завхан аймгийн Идэр сумын нутагт Хамбын хүрээ байгуулагдав.

1732. Орхон голд түшээ гүн цол олгов.

# XVIII

## ЗУУН

1733. Манжийн төрөөс Монголын ноёдод пундүү олгож эхлэв. Улиастай хотын суурь тавигдав. Манзуширийн хийдийг байгуулж эхлэв.

1735. Ломн Монгол боржигид овгийн түүхийг зохиов.

1736. Манж Чин улсын Тэнгэрийн тэтгэсэн хааны 1-р он эхлэв. Амарбаясгалант хийд баригдаж дуусав.

1737. I нар баячин хутагт Бадамдорж нас барав.

1739. Ширээт гүүш Дарма Дарма «Алтан хүрдэн, минган хигээст»-г зохиов.

1739. II Жибзундамба Дэчингарлин сургаалийн дацан байгуулав.

1740. Цахар гэвн Лувсандүлтэм төрөв.

1741. Буриадын анхны дацан хамбын хүрээ байгуулагдав.

1741. Улаанбаатарт Ганцан хүрээ байгуулагдав.

1742. «Мэргэд гарахын орон» төвд монгол толь зохиогдов.

1743. Түшээт хан Довдондорж нас барав.

1745. Манж нар Монголчуудын угийн бичиг, түүхийг Бээжинд хэвлэх нэрээр хураан устгаж эхлэв.

1746. Цэвээндоржнамжил Ойрадыг захирав.

1746. III Жалханэ хутагт Галсандамбийримшил төрөв.

1747. Их хүрээ Сэлбэд буув.

1747. Манзуширийн хийдийг барьж дуусав.

1748. Сүмба хамбо Ишбалжир (1704-1788) «Энэтхэг, хятад, түнд, монгол оронд бурхны шашин дэлгэрсэн түүх» (Багмамжонсан) хэмээх зохиолыг бичив.

1751. Чин сүжигт номун ханд тамга олгов.

1752. Даваач Ойрадын хаан болов.

1753. Дөрвөд аймаг Манжийн захиргаанд оров.

1754. Дөрвөд Далай хана аймаг, Улаангомын хүрээ байгуулагдав.

Халхын Түшээт хан, Засагт хан нарын тэмцлийг таслахаар Манжийн Энх Амгалан, Түвдийн Далай ламын нэр нөлөөг ашиглан чуулган зарласан бөгөөд 1686.08.16-д одоогийн Баянхонгор аймгийн Заг сумын нутаг Заг Байдрагийн Хүрэн бэлчирт Түшээт хан Чахундорж, Өндөр гэгээн, Сэцэн хан Норов, Засагт хан Шар зэрэг Халхын нэр нөлөө бүхий 60 гаруй ноёд хүрэлцэн очсоны сацуу Далай ламын төлөөлөгч Галдан ширээт, Манжийн эрхэлсэн сайд Арнай нар байлцжээ. Манжийн сайд Арнай харилцан найрамдахыг ятгасан Энх Амгалан хааны зарлигийг уншиж сонсгожээ. Наймдугаар сарын 22-д баруун гараас Засагт ханы төрлийн тайж Саран ахай, зүүнээс Түшээт ханы дүү Сэлшир баатар нар харилцан найрамдах үг хэлж тангараг тавьж, Халхын зүүн, баруун гарын бүх ноёд тэврэлдэн золгоцгоожээ. Маргааш нь Галдан ширээт, Жибзундамба хутагтын өмнө бурхны хөрөг залж, бүх ноёд хойшид эвтэй явахыг харилцан тангарагласан ба 1662 оноос хойш зүүн, баруун гарын дотор дүрвэн гарсан тайж, ардыг тус тусын эздэд эгүүлэн өгөхөөр тогтжээ.

## АР ЭЛСТЭЙН ЧУУЛГАН

Халхын Засагт ханы ширээний төлөөх тэмцэл даамжирч Зүүнгар улсын Галдан хаан, Манжийн Энх-Амгалан хаан, Түвдийн Далай лам оролцсон олон улсын шинжтэй хэрэг болж хувирчээ. 1688 оны хавар эхэлсэн Халх, Ойрадын дайны явцад халхчууд ялагдаж, өмнөд Монголын нутаг руу зугтан орсон бөгөөд Халхын хаад ноёд 1688 онд Шилийн голын чуулганы сөнөд хошууны нутаг Ар Элстэйд чуулж Манжид дагаар орох шийдвэр гаргажээ. Уг чуулганд Засагт хан аймгийг төлөөлөх хан байхгүй байсан бөгөөд баруун гарын ноёдоос хэн хэн оролцсон нь тодорхойгүй. Ар Элстэйн чуулганы дараа манж Халхын баруун гарын ноёдод Өвөр Монголын нутагт түр нутаг олгон суулгажээ.

## ДОЛООН НУУРЫН ЧУУЛГАН



Халх монголчууд Манжийн эрхийлдэд оров

1691 онд халх монголчуудыг Манж Чин Улсын харьяат болгох ёслолыг өмнөд Монголын Долоон нуурт (одоогийн Доудон) хийжээ. Манжийн Энх Амгалан хаан, Долоон нуурын Асу хаалганы өмнөх шар асарт Жибзундамба хутагт тэргүүтэй Халхын ноёдыг угтан авч Халх Монголыг захиргаандаа оруулсан зарлигийг танилцуулжээ. Долоон нуурт Халхын 550 орчим ноёд тайж нар, өмнөд Монголын зарим нөлөө бүхий ноёд очсон байна. Уг чуулганаар Халх Монголын тусгаар тогтнолыг устгаж Манжийн засаглалыг тогтоов. Халхыг 3 аймаг, 34 хошуу болгон хувааж, хошууны засаг ноёдыг тохоов. Мөн Халх Монголын ноёд язгууртнуудын зэрэг дэв,

# ОРОС, ХЯТАД, МОНГОЛ ГУРВАН УЛСЫН ХИАГТЫН ГЭРЭЭ



Да лам Дашжав

Гадаад Монголын статусыг тодорхойлсон Хятад, Орос, Монгол гурван улсын хэлэлцээр Хиагт хотноо 1914 оны есдүгээр 8-д ажлаа эхэлжээ. Хүрээнд суугаа ерөнхий консул А.Я.Миллер Оросын төлөөлөгчдийг толгойлсон бол Хятадын засгийн газрын төлөөлөгчдийг Манжуур дахь цэргийн генерал Би Гуйфан тэргүүлж бүрэлдэхүүнд нь Чэнь Лу, Чэнь И нар багтжээ. Монголын талыг Дотоод яамны тэргүүн сайд Дашжав ахлаж, Сангийн яамны тэргүүн сайд Г.Чагдаржав, өвөрлөгч ван Удай, Баргын Дамдинсүрэн, Гадаад яамны дэд сайд Б.Цэрэндорж нар оролцсон. Хэлэлцээрийн явцад Оросын шахалтаар Дашжав, Дамдинсүрэн нарыг Монголын Засгийн газар татан авч оронд нь

нолон ван Ширендамдинг илгээжээ. Хиагтын гурван этгээдийн хэлэлцээрийн хурал албан ёсоор 40 гаруй удаа хуралдаж жил шахам үргэлжилжээ. Хэлэлцээрээр Орос, Хятад улс 1913 онд тохиролцсон Бээжингийн тунхагийн үзэл санааг Монголд тулган хүлээлгэсэн, Хиагтын гэрээгээр Монгол Улсын хувь заяа, статусын асуудал шийдэгдэж, Ар Монгол нь Бүгд Найрамдах Хятад Улсын сюзеренитет эрхийн доор автономит эрхтэйгээр орших, Оросын онцгой эрх ангийг хүлээсэн статустай болон хувирчээ. Гэхдээ хэлэлцээрээр Монгол нь эзэн хаан, үндэсний засгийн газар, нутаг дэвсгэр, хил хязгаар, үндэсний цэрэгтэй байж, дотоод бүх асуудлаа бие даан шийдэх эрхээ баталгаажуулж чадсан.

Тэрчлэн өөрийн нутагт Орос, Хятадын цэргийн хүчнийг оруулахгүй байх, дотоод хэрэгтээ тэднийг оролцуулахгүй байх, худалдаа, үйлдвэрийн асуудлаар олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах эрхийг гэрээнд тусган зөвшөөрүүлжээ. Хиагтын гэрээг дөрвөн хэлээр үйлдэж маргаан гарваас франц хэлээр үйлдсэн эхэ баримтлахаар тохиролцсон байна. Энэ гэрээгээр Монгол Улс тусгаар тогтнолоо автономийн хэмжээнд хүртэл хязгаарлуулсан хэдий ч бие даасан байдлаа хадгалан үлдэх, олон улсын эрхзүйн баталгааг бий болгож чадсан юм.

# 1915

2/19. Гадаад яамны тэргүүн сайд хошой чин ван М.Хандорж учир битүүлгээр нас баражээ.

5/14. Оросын хөрөнгөтнүүд «Монголын үндэсний банк» хэмээх банкныг Хүрээнд байгуулжээ.

5/25. Монгол Орос Хятадын гурван этгээдийн хэлэлцээр байгуулагджээ. Уг хэлэлцээсээр Монголын тусгаар тогтнолыг цуцалж, Гадаад Монголд автономит статусыг тулган хүлээлгэжээ.

6/. Дундад Иргэн улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Их Хүрээнд сууж хэрэг шийтгэх их түшмэл, Ховд, Уластай, Хиагтад сууж туслан шийтгэх түшмэл нарыг томилжээ. Харчин гүн Бавуужавын удирдлагаар Хиагтын гурван этгээдийн хэлэлцээрийг эсэргүүцэн цэргийн бослого гарчээ.

8/. Оросын эрдэмтэн, хурандаа П.Кооловын экспедиц Монголд ажлаа эхэлжээ.

11/22. Хятадын цэрэг Егүээр хутагтын хийдийн чиглэлээр Монгол Улсын хилд цөмрөн орж, тус хязгаарын сайд Егүээр хутагт Галсандашийг ололон авч оджээ.

12/. Дундад Иргэн улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж, Ерөнхий сайд Намнансүрэн, Бадамдорж, Лувсанбалдан, Ширендамдин, Цэрэндорж нарыг нэгдүгээр цэргийн одонгоор шагнажээ.

12. Шүүх яамны тэргүүн сайд Сэцэн хан Навансүрэн нар Бээжинд айлчилж, Хятадын Ерөнхийлөгчид бараалхсан ба хязгаарын сайд Галсандашийг суллуулахаар хоноцоджээ.

Оросууд Хүрээнд дэх консулын газраа Ерөнхий консулын газар болгожээ.

Монголын баруун, баруун өмнөд хилээр цөмөрсөн Хятадын цэргийг цохин хөөв.

## НИЙСЛЭЛ ХҮРЭЭНИЙ СОНИН БИЧИГ

*Нийслэл Хүрээний сонин бичиг*-ийн анхны дугаар гарчээ. Уг сонин тухайн үеийн Монгол орны төрийн гадаад, дотоод байдлыг харьцангуй бодитой бөгөөд өргөн дэлгэр тусгаж дэвшилтэт ардчилсан үзлийг сурталчилж байв. Ж.Цэвээн, Д.Бадрахбаатар, Д.Бодоо, Б.Дорж, Н.Намсрай, Д.Энхдэн, Н.Жанцансамбуу нар уг сонинд ажиллаж байв. Сонинны нийслэл нь эн тэргүүнд улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг өмгөөлөн тэмцэж, харийн түрэмгийллийг устгах, нийгмийн хоцрогдол, ихэс ноёдын харгис хэргийг байдлыг шүүмжлэх, ард олны эрх ангийг хамгаалах, тэдэнд боловсрол соёлыг эзэмшүүлэх, гэгээрүүлэхэд чиглэж байв. *Нийслэл Хүрээний сонин бичиг*-ийн сүүлийн дугаар 1920.01.23-д гарчээ.

# 1916

## УЛСЫН ХӨРӨНГӨ ЗАХИРАХ ГАЗАР

6/7. Богд хаантан Дундад Иргэн улсын Ерөнхийлөгчөөс шийтгэн олгосон тамга, өргөмжлөлийг хүлээн авчээ.

6/20. Орос, Япон хоёр шинэ гэрээ байгуулж, үүндээ Монголд хамаарах түүрүүний нууц тохиролцоогоо дахин баталгаажуулжээ.

10/20. Жилд 400 Монголчуудыг шэргийн эрдэмд суралцуулах тухай Орос Монголын хэлэлцээр байгуулагдв.

Хүрээнд Монгол, Орос, Хятадын гурван этгээдийн хэлэлцээ болж, дахингаан мэдээний асуудаар гэрээ байгуулжээ.

Оросын дэд консулын газрыг Хиагтад байгуулахаар хоёр тал тогтжээ.



Григор С. Козин (баруун гар талд) хэвжиг Говжин нэрээрээ Монголд мөнхрөх тавилантай илээн байв.

Оросоос уригдаж ирсэн мэргэжилтэн түшмэл С.А.Козин, түүний орлогч П.А.Витте нарын санаачилга, оролцоотойгоор «Улсын хөрөнгийг захирах газар» хэмээх газрыг байгуулж, дүрмийг нь баталжээ. Дүрэмд Монгол Улсын хязгаарын доторх газрын хөрсөн дээрх ба доорх бүх баялгийг улсын өмч хөрөнгө гэж албан ёсоор зарласан юм. Улсын хөрөнгийг захирах газар нь Монголын нутаг дэвсгэрт бүхий байгалийн баялгийг ашиглуулахдаа зохих болзол нөхцлийн дагуу түрээслэн олгох, түүнээс орох орлогыг улсын санд оруулж байх үүрэг хүлээж байв.



Хүрээ-Чуулалт хаалганы зам нь худалдаа наймааны гол зам болж байв.

## ХҮРЭЭ ЧУУЛАЛТ ХААЛГАНЫ АВТО ТЭЭВРИЙН ХОРОО

Америкийн нүүсийн төлөөлөгч Чуулалт-Ларсон 1916 онд Нийслэл Хүрээнд ирж Нийслэл Хүрээ-Чуулалт хаалганы хооронд автомашины харилцаа тогтоох асуудаар Монголын эрх баригчидтай хэлэлцээ хийж Хүрээ-Чуулалт хаалганы хооронд ачаа тээвэр, зорчигч тээвэрлэх 10 машин бүхий Тяньжиний авто тээврийн хороо хэмээх газрыг байгуулжээ. 1918 оноос Их Хүрээ – Чуулалт хаалганы гадаадын хувийн нүүсийн авто тээврийн тогтмол харилцаа бий болжээ.

## МОНГОЛЫН СУРАГЧИД НУТАГТАА БУЦАВ

Монгол Улсын Засгийн газраас Хаант Оросын Эрхүү, Хиагт хотод 1913 оноос арваад хүүхдийг сургахаар илгээжээ. Гэвч Дэлхийн I дайнд Орос улс татагдан орсноор юмны үнэ нэмэгдэн гачигдал зүдрэл үлэмж болсны дээр 1917 онд хаант засгийг халж, цагийн байдал, хүн иргэний санаа сэтгэл тогтворгүй болж ирсэн тул тэдгээр сурагчдыг буцаан татан авч, Хүрээний сургуульд үргэлжлүүлэн сургажээ. Бат-Очир, Жадамба, Найдансүрэн, Бадарчин, Дамбадорж, Чойбалсан нарын олон хүүхэд Орост суралцсан бөгөөд тэдний дотроос сайн суралцагсдыг шагнаан урамшуулж байжээ.



Решений лицейд суралцагчид

## ХУДАЛДААНЫ ХОРШОО БАЙГУУЛАХ ОРОЛДЛОГО

Монголчуудын дунд худалдаа наймаа гардан эрхлэх явдал нэлээд өргөн хүрээтэй болж, Бөөгийн Шагдар, Бүтэмж гэлэн, гандан Балжир, Шадав гавж зэрэг нэрд гарсан баячууд төрөн гарчээ. 1917 онд Цэдэвсүрэн гүн, Чагдаржав лам нарын Нийслэл Хүрээний 18 худалдаачид хувь хөрөнгө нийлүүлж «Монголын харилцан туслах хоршоо» байгуулж, Монголын түүхий эд, гаднын эд таваарыг бусдаар дамжуулахгүй шууд гардан худалдаалж, хувьдаа болон улсдаа ашигтай ажиллах зорилго агуулж байв. Гэвч идэвхтэй үйл ажиллагаа явуулж чадсангүй зөгсчээ. Монголын худалдаачид, дэвшилт үзэлтнүүд үндэсний мөнгөн тэмдэгттэй болох, жин хэмжүүрийг нэг мөр болгох, зам харилцааг сайжруулах, үндэсний банк байгуулахыг шаардаж байв.



Нийслэл Хүрээний зах зээлийн газар

# 1917

8/20. Петроград Оросын Түр засгийн газар Монголын асуудлыг тусгайлан авч хэлэлцжээ.

Харчин гүн Бавуужавын нэр барьсан цэргийн үлдэгдэл хүнийг Хатанбаатар Магсаржавын цохиж хөөв.

11/. Хүрээний эх баригчид Зөвлөлт засгийг төлөөлөх консулын ажилтнуудыг Монголд оруулахаас татгалзжээ.

11/7. Орост октябрь сарын эргэлт гарч төрийн эрхийг большевик тэргүүтэй зүүний хүчнийхэн авчээ.

12/17. Хятад, Монголын төлөөлөгчид Хүрээнд «Урианхайн хязгаарыг автономит Монголын салшгүй хэсэг мөн» гэх хэлэлцээр байгуулжээ.

Оросоос Монголд нүүн суурьших хөдөлгөөн идэвхжиж есөн мянга гаруй Монголын нутагт орж иржээ.

Хүрээнд «Орос иргэдийн гүйцэтгэх зөвлөл» байгуулагджээ.

Хатанбаатар Магсаржавын цэрэг Улаанцавын чуулганы нутгаар халдан довтолсон хятадын цэрэгтэй тулалджээ.

Сайн ноён хан аймагт анхны хувийн сургууль байгуулагдлаа.

# 1918

3/. Хуровд суугаа Оросын консулын газраа шинэ хэрүүс томилсныг ЗОУ-ын Засгийн газраас Монголын Засгийн газраа мэдэгдэхийн хамт хоёр талын хооронд эрх тэгш найрсаг харилцаа тогтоохыг санал болгожээ.

5/. Хүрээний эх баригчид Зөвлөлт Засгийн газрын консулын ажилтнуудыг оруулахас дахин татгалзжээ.

8/. Хятадын цэргийн түрүүч Нийслэл Хүрээнд орж ирэв.

Монголын Засгийн газар ЗОУ-тай найрсаг харилцаа тогтоохоос татгалзжээ.

8/3. ЗОУ-ын Засгийн газраас хаант Орос улсын Монголд эдэлж байсан бүх эрхээс татгалзсан, дотоодын хэрэг нь оролдохгүй, дипломат харилцаа тогтоох тухай уриалга гаргажээ.

9/. Бээжингийн эрх баригчид «большевикоийн аюул»-аас хамгаалах нэрийдлээр Монголд цэрэг оруулж эхэлжээ.

10/. Монгол, Урианхайн хязгаарыг Богд гэгээний харьяа болгон зарлаж Монголын амбан захирагчийг томилжээ.

11/. Омьскт Колчакийн Засгийн газар байгуулагджээ. Монголын Засгийн газар тус Засгийн газартай харилцаж байв.

Буриадаас Ар Монголд олон мянган айл нүүдэллэн Монголд орж иржээ.

Татван урианхайн нутгийг бусинулж байсан цагаантны цэргийг С.Магсаржавын цэрэг улаан цэрэгтэй хамтран тулалдаж хөөжээ.

## МОНГОЛ УЛСЫН ШАСТИР

Монгол Улсын Засгийн газраас эрхлэн «Зарлигаар тогтоосон Монгол Улсын шастир» хэмээх 11 дэвтэр улсын албан түүхийг зохиолгожээ. Тэрхүү зохиолыг Цэрэндэндэв, Гомбоцэрэн, Галсандоной, Ш.Дамдин, Сумъяа, Дашиням, Тогтох, Намсрайжав нарын эрдэмтэн түүхчид бүтээжээ. «Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир»-т Монгол нь ерөөс эртний түүхт тусгаар улс бөгөөд нэгэн үед Манж Дай Чин улсад дагаар орж явсан боловч 1911 онд шашин төрнийг хослон баригч хаант улсыг байгуулж, Монголын тулгар төрийг дахин нэгээн болохыг онцлон заажээ.



XX зууны эхэнд монголчуудыг үстэж байгаа үндэстэн гэх үзэж байлаа.

## ХҮН АМЫН ТООЛЛОГО

1918 онд Монгол Улсад хүн амын тооллого явагдсан нь XX зуун дахь хүн амын анхны статистик бүртгэлийн суурь болж өгдөг юм. Энэ тооллогоор зөвхөн Халх дөрвөн аймгийн хүн амыг тоолсон бололтой, Ховдын хязгаар, Их шавийн хүн ам, тус улсад суугаа гадаадын иргэд хамрагдаагүй байна. Халх дөрвөн аймаг, 104 хошууны хүн амын тоо 405707 гэж бүртгэгджээ. Үүнээс Түшээт хан аймгийн 21 хошуунд 100.132, Сэцэн хан аймгийн 28 хошуунд 101.676, Засагт хан аймгийн 23 хошуунд 70.151, Сайн ноён хан аймгийн 32 хошуунд 133.748 хүн тоологджээ. Энэ тооллогын дүн, баримтыг Монгол орноор аялж судалгаа хийж явсан И.Майский олж авч дүн шинжилгээ хийн дутуу хэсгийг гүйцэлдүүлэхийг оролдсон байдаг.